



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 10 сарын 19 өдөр

Дугаар

157

Улаанбаатар хот

Биеийн тамир, спортын барилга,
байгууламжийн бүртгэл, тооллогыг
зохион байгуулах тухай

“Биеийн тамир, спортын тухай” хуулийн 21 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх, түргэн шуурхай хүртээмжтэй болгох, биеийн тамир, спортын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах зорилгоор нийслэлийн хэмжээнд ашиглагдаж байгаа биеийн тамир, спортын барилга, байгууламжийн бүртгэл, тооллогын ажлыг зохион байгуулсугай.

2. Нийслэлийн хэмжээнд ашиглагдаж байгаа биеийн тамир, спортын барилга байгууламжийн бүртгэл тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх ажлыг чанарын өндөр түвшинд зохион байгуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, мэргэжилтэн Г.Бямбасайханд даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНБОЛД



Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2015 оны дугаар сарын 19-ны өдрийн
А/57 дугаар тушаалын хавсралт



Биеийн тамир, спортын барилга, байгууламжийн
бүртгэл, тооллогыг зохион байгуулах
Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ахлагч: Г.Бямбасайхан	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын мэргэжилтэн
Гишүүд: Б.Батсайхан	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын мэргэжилтэн
Б.Түвшинбаяр	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын мэргэжилтэн
Ж.Болдбаатар	Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хорооны ахлах мэргэжилтэн
Д.Алтанхуяг	Багахангай дүүргийн Биеийн тамир, спортын хорооны ахлах мэргэжилтэн
Б.Баттөр	Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хорооны ахлах мэргэжилтэн
Ю.Батсайхан	Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны ахлах мэргэжилтэн
С.Баасанжав	Налайх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны ахлах мэргэжилтэн
Б.Отгонбаяр	Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хорооны ахлах мэргэжилтэн
Д.Энхбаяр	Сүхбаатар дүүргийн Биеийн тамир, спортын хорооны ахлах мэргэжилтэн
М.Гантөмөр	Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спортын хорооны ахлах мэргэжилтэн
Ц.Өлзийбаатар	Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хорооны ахлах мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга: Н.Өлзийжаргал	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын мэргэжилтэн